



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

БИЧИЛ УУРХАЙ ДАХЬ ЗӨРЧИЛ, МАРГААН, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ





Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

БИЧИЛ УУРХАЙ ДАХЬ ЗӨРЧИЛ, МАРГААН, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

*(Бичил уурхайн оролцогч
талуудад зориулсан
гарын авлага)*

Улаанбаатар хот
2017 он

ДАА 622
ННА 33
Э-66

Бичил уурхай дахь зөрчил, маргаан, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх арга зам

Боловсруулсан: Т. Энхцэцэг

Хянан тохиолдуулсан: Т. Ихтамир

@Бүх эрхийг Швейцарийн хөгжлийн агентлагийн
Тогтвортой бичил уурхай төсөл эзэмшинэ.

ISBN 978-99978-2-014-3

Оршил

Монгол Улсын Засгийн газар, Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хамтран 2005 оноос Тогтвортой бичил уурхай төслийг хэрэгжүүлж байна. Төслийн 4 дэх үе шатны зорилго нь “Эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хариуцлагатай, хүний эрхэд суурилсан Монгол Улсын бичил уурхайн салбар нь бичил уурхайн талаарх олон улсын туршлагаас суралцах, үр шимийг хүртэхийн зэрэгцээ өөрөө хувь нэмэр оруулахад оршино. Хариуцлагатай бичил уурхай төлөвшихөд бичил уурхай эрхлэгчид ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаатай нь холбогдон тэдний дотоодод болон бусад талуудтай харилцахад гарах аливаа зөрчил, маргааныг бие даан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, түүнийг шийдвэрлүүлэх мэдлэг, чадавхтай болсон байх нь нэн чухал ач холбогдолтой юм.

Бичил уурхайн эрх зүйн орчин орчин бүрдсэн хэдий ч бичил уурхай эрхлэгчид болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд, нутгийн засаг захиргааны болон өөрөө удирдах байгууллага, байгалийн нөөц, баялаг ашиглагч бусад талууд болох малчид, тариаланчид, нутгийн иргэдийн хооронд олон төрлийн зөрчил, маргаан гарсаар байна.

Иймд бид Хүний эрхийн үндэсний комисстой хамтран бичил уурхай дахь зөрчил, маргаан, өргөдөл, гомдол, түүнийг шийдвэрлэх арга замуудын талаар ерөнхий ойлголт өгөх зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулж бичил уурхайн оролцогч талууд та бүхний оюуны мэлмийд толилуулж байна.

Швейцарийн хөгжлийн агентлагийн тогтвортой бичил уурхай төсөл

Гарчиг

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. 5 **ЗӨРЧИЛ, МАРГААН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ НЬ 5**

- 1.1. Зөрчил, маргааны талаарх ерөнхий ойлголт 5
- 1.2. Бичил уурхай дахь зөрчил, маргаан түүнийг шийдвэрлэх арга зам 9

ХОЁРДУГААР БҮЛЭГ. 24 **ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ НЬ 24**

- 2.1. Өргөдөл, гомдлын талаарх ерөнхий ойлголт 24
- 2.2. Өргөдөл, гомдлоо хэнд гаргах вэ? 27
 - 2.2.1. Монгол Улсын Их Хурал 28
 - 2.2.2. Засгийн газар, яам, агентлаг 31
 - 2.2.3. Орон нутгийн засаг захиргааны байгууллага 31
 - 2.2.4. Шүүх 33
 - 2.2.5. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 39
 - 2.2.6. Прокурорын байгууллага 43
 - 2.2.7. Цагдаагийн байгууллага 46

Нэгдүгээр бүлэг.

Зөрчил, маргаан, түүнийг шийдвэрлэх нь

Бид энэ бүлэгт байгалийн баялаг ашиглахтай холбоотой зөрчил, маргаан, түүний элементүүд, хэмжигдэхүүн, шинж чанар, түүний шалтгаан, төрөл, илрэх үе шат, хариу үйлдэл, эрсдэл, зөрчил, маргаанаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх арга замын талаарх ерөнхий ойлголтыг авч үзэх болно.

1.1. Зөрчил, маргааны талаарх ерөнхий ойлголт

Зөрчил, маргаан гэдэг нь хоёр буюу түүнээс дээш оролцогч талуудын хооронд шууд ба шууд бусаар хөндөгдөж болохуйц ашиг сонирхол, хэрэгцээ, зорилго, үнэт зүйлс, итгэл үнэмшлийн бодитой буюу хийсвэр ялгаанаас үүссэн харилцааг хэлнэ.

Зөрчил, маргааны элементүүд:

Хүмүүс: Тэдний бодол санаа, сэтгэл хөдлөл болон үйлдлүүд

Үйл явц: Шийдвэр гаргах явц, түүнд үзүүлэх хариу үйлдэл

Асуудал: Хүмүүс, бүлгүүд, байгууллагуудын хооронд үүссэн тодорхой асуудлууд, тэдгээрийн хоорондын ялгаа.

Зөрчил, маргааны хэмжигдэхүүн:

Зөрчил, маргааны эх сурвалж нь ихэнхдээ олон талт, ээдрээтэй байдаг. Зөрчил, маргаан нь байнга өөрчлөгдөж байдаг нийгмийн харилцааны үйл явц юм. Нэг дор хэд хэдэн зөрчил, маргаан зэрэгцэн явагдаж байх нь нийтлэг байдаг. Зөрчил, маргааны талаар “үнэн” бөгөөд “бодитой” тайлбар гэж байхгүй.

Зөрчил, маргааны шинж чанар:

- Зөрчил, маргаан нь нийгэмд, амьдралд тохиолддог ердийн үзэгдэл бөгөөд ихэнхдээ өөрчлөлт, шинэчлэлт шаардлагатай байгааг илэрхийлдэг.
- Зөрчил, маргаан нь асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн алхам
- Зөрчил, маргаан нь оролцогч бүх талуудад хамаатай
- Зөрчил, маргаан нь үйл явц
- Зөрчил, маргааныг зохицуулж болно.

Зөрчил, маргааны шалтгаан:

- Байгалийн баялгийн төлөөх өрсөлдөөн
- Нийгмийн бүтэц, тогтолцооны гажуудал
- Эдийн засаг, нийгмийн өөрчлөлтүүд
- Байгалийн нөөцийн менежментийн талаарх бодлого, хөтөлбөр



Зөрчил, маргааны төрлүүд:


- Бүлгийн доторх
- Бүлэг хоорондын
- Бүлгүүд болон төр засгийн хоорондын
- Бүлгүүд, төрийн бус байгууллагууд, хувийн ашиг сонирхлын хоорондын
- Дээрх бүх талуудын хоорондын

Зөрчил, маргаан нь шулуун шугамаар явагддаг процесс биш. Зөрчил, маргааны процесс нь урагш, хойш, дээшээ, доошоо янз бүрийн чиглэлтэй байдаг.

Зөрчил, маргааны үе шат:

- *Далд:* Ил биш боловч нуугдмал буюу хараахан хурцдаагүй нийгмийн тайван бус байдал, ялгаа, зөрүүтэй үзэл бодол бий болох.

- *Илэрч буй*: Зөрчил, маргаан бодитой болж аажмаар юм уу богино хугацаанд нээлттэй болж хүлээн зөвшөөрөгдөн олон нийтэд анзаарагдах хэмжээнд хүрэх
- *Хурцдах*: Хүчирхийлэлд хүрч даамжрах.



Зөрчил, маргаанд үзүүлэх хариу үйлдэл:

- *Зайлсхийх*: аль аль талдаа ашиггүй
- *Хүч хэрэглэх*: нэг нь хожиж нөгөө нь алдана
- *Эвлэрэх*: нэг нь алдаж нөгөө нь хожино
- *Харилцан буулт хийх*: аль аль нь хожиж бас алдана
- *Хамтын ажиллагаа*: хэн хэн нь хожино



Хариу үйлдэл	Мөн чанар
Зайлсхийх	<ul style="list-style-type: none"> • Хойшлуулах, ухрах, удаашруулах тактик хэрэглэж талуудын ашиг сонирхлыг хөсөрдүүлнэ. • Оролцохоос амар мэт санагдаж болно. • Дангаар нь хэрэглэвэл 2 тал алдах болно. • Зуурдын шийдэл болно.
Хүч хэрэглэх	<ul style="list-style-type: none"> • Нэг бүлэг нөгөө бүлэгт сонирхлоо тулгана. • Хүч хэрэглэх, заналхийлэх, сүрдүүлэх, хараах, шахалт үзүүлэх зэрэг үйлдэл гаргана. • Дургүйцэл, дайсагнал үүсгэнэ. • Ямар үр дүнд хүрэх нь тодорхойгүй. • Талууд хамтран ажиллах сонирхолгүй болно. • Нэг нь хожиж, нөгөө нь алддаг.
Эвлэрэх	<ul style="list-style-type: none"> • Бусдын сонирхолд нийцэх боловч өөрийнхийг орхигдуулна. • Талууд цаг их зарахгүй байх сонирхолтой үед хэрэглэж болно. • Нэг тал нь харилцааг хадгалах сонирхолтой эсвэл илүү хүчтэй үед хэрэглэж болно. • Нэг тал алдаж, нөгөө тал хожно.
Харилцан буулт хийх	<ul style="list-style-type: none"> • Түргэн шийдэлд хүрэх зорилгоор хэрэглэнэ. • 2 тал өөрсдийн сонирхлоо золиосолж байж 2 талд ашигтай шийдэлд хүрнэ. • Талууд нэг зүйл золиосолж нөгөө зүйлийг хожно. • Нэг бол 2 тал хожно, нэг бол 2 тал алдана.
Хамтран ажиллах	<ul style="list-style-type: none"> • Бүх талуудын ашиг сонирхлыг хангахыг хичээнэ. • Зорилго, хамтарсан шийдвэрийг чухалчилна. • Бүх талуудыг тэгш, идэвхтэй оролцуулахын тулд цаг хугацаа хэрэгтэй. • Бүх талуудад харилцан ашигтай, хожоотой. • Бүх талууд асуудлыг нааштайгаар шийдэхийг хүссэн үед чухал ач холбогдолтой.

Дээрх хариу үйлдлүүдээс хамтын ажиллагаа нь хэн хэн нь хожих харилцан ашигтай үр дүнд хүрэх боломжийг олгоно.

Хамтын ажиллагаа нь янз бүрийн ашиг сонирхол бүхий хүмүүс хэн хэнийхээ ашиг сонирхолд нийцсэн үр дүнд хүрэхээр хамтран хичээн зүтгэж буй үйл явц мөн.

Зөрчил, маргааныг шийдвэрлэх арга замууд:

Монгол Улсад зөрчил, маргааныг шийдвэрлэхдээ дараах хоёр арга замыг ашиглаж байна.

1. *Уламжлалт арга барил:* Зөрчил, маргаанд оролцогч талууд өөрсдийн түвшинд хоорондоо зохицон, зөвшилцөх замаар асуудлыг шийдвэрлэнэ.
2. *Албан ёсны эрх зүйн механизм:* Талууд зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд хамгийн эцсийн шатанд шүүхийн эсвэл захиргааны журмаар шийдвэрлүүлэх (энэ талаар бид Хоёрдугаар бүлэгт дэлгэрүүлж тайлбарлана) албан ёсны эрх зүйн механизмыг ашиглах арга замыг сонгох эрх талуудад нээлттэй байдаг.

Зөрчил, маргааныг шийдвэрлэхийн тулд нэн тэргүүнд зөвшилцөлд хүрэх хэлэлцээр, зуучлалын аргыг хэрэглэх нь илүү үр дүнтэй байдаг. Хэлэлцээр нь зөрчил, маргаантай талуудын зөвшилцөл, тохиролцоонд хүрэх сайн дурын үйл явц бөгөөд зөвшилцөл нь бүх талуудын хүлээн зөвшөөрсөн хамтын шийдвэр байдаг. Харин зуучлал нь зөвшилцлийн үйл явцыг эрчимжүүлэх зорилгоор төвийг баримтлагч гуравдагч этгээдийн туслалцаатайгаар хэлэлцээр хийх үйл явц юм. Зөрчил, маргааныг албан ёсны эрх зүйн механизмаар буюу шүүхийн эсвэл захиргааны журмаар шийдвэрлүүлэх тохиолдолд гарсан шийдвэр нь заавал биелэгдэх, дагаж мөрдөх шинжийг агуулдаг.

1.2. Бичил уурхай дахь зөрчил, маргаан түүнийг шийдвэрлэх арга зам



Бичил уурхайд нийтлэг гардаг зөрчил, маргааны шалтгаан:

- Олборлолт явуулах газрын асуудал
- Бичил уурхайн эрх зүйн орчин
- Эрдэс баялгийн тэгш бус хуваарилалт
- Хүний эрх, ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдал
- Бичил уурхай эрхэлж буй байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн ил тод байдал, хариуцан тайлагнал, хувийн ашиг сонирхол

Бичил уурхай дахь зөрчил, маргааны төрлүүд:

- Бичил уурхайчид болон уул уурхайн компаниудын хоорондын
- Бичил уурхайчид болон малчдын хоорондын
- Бичил уурхайчид болон орон нутгийн удирдлагууд, хууль хэрэгжүүлэгч, сахиулагч байгууллагын хоорондын
- Тухайн орон нутгийн бичил уурхайчид болон бусад орон нутгаас ирсэн хувиараа ашигт малтмал олборлогч иргэд хоорондын

Бичил уурхайчдын нөхөрлөл, хоршоо болон бичил уурхайчдын байгууллагын дотоодын гэх мэт

Дээр дурдсан зөрчил, маргааныг шийдвэрлэхэд уламжлалт арга замыг буюу зөвшилцөлд хүрэх хэлэлцээр ба зуучлалын аргыг аль болох сонгож хэрэглэх нь илүү үр дүнтэй болохыг зөвлөж байна.

Зөвшилцөлд хүрэх хэлэлцээр ба зуучлалын аргыг хэрхэн ашиглах талаарх үндсэн гарын авлага нь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-ын “Байгалийн нөөцийн менежментийн хэлэлцээр ба зуучлалын аргууд”¹ (2005) хэмээх баримт бичиг юм.

Энэхүү гарын авлагад дурдсан зөвшилцөлд хүрэх хэлэлцээрийн үйл явцыг ашиглах арга техникийн дагуу бичил уурхайн оролцогч талууд дахь зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар дор авч үзье.

Зөвшилцөлд хүрэх хэлэлцээрийн үйл явцыг зөрчилд хамаатай талууд шууд яриа хэлэлцээр хийх, эсвэл гуравдагч этгээд буюу зуучлагчийн тусламжтайгаар дор дурдсан дөрвөн үе шат, арван алхмыг хэрэгжүүлнэ.

¹Антониа Энгел, Бенедикт Карф нарын 2005 онд боловсруулсан Байгалийн нөөцийн менежментийн хэлэлцээр ба зуучлалын аргууд номыг Тогтвортой бичил уурхай төслийн хүрээнд 2008 онд монгол хэлнээ хөрвүүлэн гаргаж хэвлүүлсэн.

А үе шат

1 дүгээр алхам: Зөрчил, маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаанд бэлтгэх.

Зуучлагчийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж, зөрчилдөгч талуудын нэр, хаяг болон бусад холбогдох мэдээллийг цуглуулна. Зөрчил, маргааны талаарх суурь мэдээллийг цуглуулж судалсны дараа зөрчилдөгч талуудтай ажиллах стратегийг боловсруулна.

2 дугаар алхам: Зөрчил, маргааны асуудалтай газар дээр нь очиж танилцах.



Зуучлагч нь зөрчилдөгч талуудтай холбоо тогтооно. Эхний удаад зуучлагч зөрчил, маргаантай талуудтай ганцаарчлан уулзаж асуудлыг хэрхэн тодорхойлж байгаа талаар судална. Үүний дараа тэд үйл явцыг ахиулахын тулд тэдний зүгээс хийх ёстой зүйлсийг тодорхойлж, талуудаас ажлаа эхлүүлэх зөвшөөрөл авна.

3 дугаар алхам: Зөрчил, маргааныг шинжлэх.

Зуучлагч өөрийн гаргасан байр сууриа тодруулж, талуудын байр сууриудыг шинжилнэ. Зөвхөн дараах нөхцөл бүрдсэн үед үйл явцыг үргэлжлүүлнэ:

- а) зөрчил, маргааныг шийдвэрлэх бусад аргууд тус болохгүй гэдэг нь тодорхой болсон нөхцөлд;

- б) тухайн нөхцөлд талуудын ашиг сонирхлын үүднээс асуудлыг хэлэлцэх нь хамгийн тохиромжтой байх үед;
- с) зуучлагч хэлэлцээрт саад учруулахгүй үед;

Зуучлагч асуудлыг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх боломжтой гэж үзэн зөрчилдөгч талуудтай зөвшилцөж шийдвэрлэсэн тохиолдолд А үе шат амжилттай хэрэгжлээ гэж үзнэ. Хэрэв хэлэлцээр үр дүнд хүрэх боломжгүй гэж үзвэл хэлэлцээрийн үйл явцыг зогсоож зөрчил, маргааныг шийдвэрлэх өөр арга замыг сонгоно.

Б үе шат

4 дүгээр алхам: Оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх.

Энэ алхмаар хэлэлцээрийн үйл явцыг хянаж, хэрэгжүүлэх үүргийг зөрчилдөгч талуудад шилжүүлэн, зөрчлийн үндсэн шалтгааныг судлан, оролцогч талуудыг танин мэдэж, өөрсдийн байр суурь, давуу талууд, сонирхол, хэрэгцээ ямар байгааг тодорхойлоход нь тусална.

5 дугаар алхам: Зөрчил, маргааныг зохицуулах боломжит хувилбаруудыг тодорхойлох, үнэлэх.

Энэ алхамаар зуучлагч нь зөрчилдөгч талуудад асуудлыг шийдвэрлэх, санал дэвшүүлэхэд нь тусална. Санал болгосон хувилбаруудын давуу болон сул талуудыг нь харьцуулж, эрэмбэлнэ.

Зөрчилдөгч буюу оролцогч талууд нь өөрсдийн байр суурийг тодорхойлж, зөрчлийг шийдвэрлэх арга барилуудыг харьцуулж, нөгөө талуудтай хэлэлцэж тохиролцоонд хүрэх хүсэл эрмэлзлээ илэрхийлсэн тохиолдолд Б шат амжилттай хэрэгжсэн гэж үзнэ. Б шат амжилттай хэрэгжээгүй тохиолдолд зөвшилцөлд хүрэх хэлэлцээрийн үйл явцыг зогсоож, өөр бусад арга замыг судалж үзнэ.

Б үе шат амжилттай хэрэгжвэл үйл явцыг цааш үргэлжлүүлнэ:



6 дугаар алхам: Хэлэлцээрт бэлтгэх.

Хэлэлцээрт сайтар бэлтгэх хэрэгтэй. Холбогдох талуудыг тодорхой зааварчилгаагаар ханган бэлтгэх, хэлэлцээрийн стратегийг боловсруулж, шийдвэрт хүрэх бүх талын нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай. Ихээхэн хурцадмал шинжтэй зөрчлийн үед зөрчилдөгч талуудыг хэлэлцээрт тус тусад нь бэлтгэх нь тохиромжтой. Тус тусад нь хэлэлцээрт бэлтгэснээр талуудыг өөрсдийн байр суурь, ашиг сонирхол, зөрчил, маргаан шийдвэрлэх боломжит хувилбаруудаа “баталгаатай буюу мэдээллийг чандлан хадгалах найдвартай” орчинд тодорхойлох боломжоор хангах юм. Бүх талууд өөрийн ашиг сонирхлыг тодорхой болгож, хэлэлцээрийг эхлүүлэхэд бэлэн, эхлүүлэх хүсэл сонирхолтой байгаа тохиолдолд л бүх талыг хэлэлцээрийн ширээнд урина.

7 дугаар алхам: Хэлэлцээр өрнүүлэх.

Талууд нэг нэгийгээ ятгаж тохиролцоонд хүрэх гэж оролддог нь зөрчлийн менежментийн хамгийн төвөгтэй үе юм. Энэ үед гарсан санал зөрөлдөөнийг тэдний байр суурь гэхээс илүүтэйгээр ашиг сонирхол, хэрэгцээ гэдэг үүднээс авч үзэх хэрэгтэй. Зөрчилдөгч талууд асуудлыг шийдвэрлэх зорилгоор гаргасан саналуудыг хүлээн

зөвшөөрвөл хэлэлцээрийн хэсэг дууссан гэж үзнэ. Эдгээр саналуудыг нэгтгэж талуудын нэгдмэл тохиролцоог бүрдүүлнэ.

8 дугаар алхам: Бүх талын хүлээн зөвшөөрөхүйц тохиролцоог боловсруулах.

Талууд тодорхой саналаар нэгдсэн байр суурьтай болсон тохиолдолд тухайн саналаа хэрхэн хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хэрхэн хяналт тавих талаар тохиролцох ёстой. Энэ үед зуучлагч хэрхэн ажиллахаа тодорхой болгоно.

Хэлэлцэгч талууд бие биеийнхээ байр суурь, ашиг сонирхлыг сонсож, зөрчлийг шийдвэрлэх нэгдмэл арга боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх, хянах аргачлалаа тохиролцсон үед В шат амжилттай хэрэгжлээ гэж үзнэ. В шат амжилттай хэрэгжээгүй тохиолдолд зөвшилцөлд хүрэх хэлэлцээрийн үйл явцыг зогсоож, зөрчлийг өөр бусад арга, замаар зохицуулан шийдвэрлэх боломжтой эсэхийг судалж үзнэ.

В үе шат амжилттай хэрэгжвэл үйл явцыг цааш үргэлжлүүлнэ:

9 дүгээр алхам: Тохиролцоог хэрэгжүүлэх болон хянах.

Тохиролцооны хэрэгжилт, хяналтад зуучлагч нь олон үүрэг хүлээж болно. Эдгээр үүргүүдийг тодорхой болгон талуудад ойлгуулсны үндсэн дээр биелүүлэх хэрэгтэй.

10 дугаар алхам: Төгсгөлд бэлтгэх.

Хүрсэн тохиролцоогоо хэрэгжүүлэх, хянах хариуцлагыг талуудад, эсхүл итгэл даасан орон нутгийн зуучлагчид хүлээлгэн өгөх тохиролцоог зуучлагч боловсруулна. Түүнчлэн зуучлагч нь талуудын дунд гарч болох зөрчлийг хожим өөрсдөө шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх стратегийг боловсруулж болох юм.

Зуучлагч нь тухайн ажлаа дуусгавар болгох боломжтой болсон тохиолдолд Г шат амжилттай хэрэгжлээ гэж үзнэ. Ийм нөхцөлд зөрчилдөгч талууд эвлэрч, хүрсэн тохиролцоогоо цаашид хэрэгжүүлэх хамтын ажиллагааны эрмэлзэл бий болсон байна. Цаашид гарч болзошгүй зөрчлүүдийг талууд бие даан шийдвэрлэх чадавх нэмэгдэж болох талтай. Г шат амжилттай хэрэгжээгүй тохиолдолд зөвшилцөлд хүрэх хэлэлцээрийн үйл явцыг зогсоож, зөрчлийг өөр бусад арга замаар зохицуулан шийдвэрлэх боломжтой эсэхийг судалж үзнэ.

Бичил уурхайчид болон уул уурхайн компаниудын хоорондын зөрчил, маргаан:

Бичил уурхайгаар олборлолт явуулах газрын асуудлаас болж бичил уурхайчид болон уул уурхайн компаниудын хооронд урт хугацааны зөрчил, тэмцэл гардаг.

1992 оноос Монгол Улсад хэрэгжиж эхэлсэн Алт хөтөлбөрийн үр дүнд тухайн үеийн уул уурхайн компаниуд хаягдал ихтэй технологи ашиглан сорчлон олборлолт явуулж, уурхайн хаалтыг зохих ёсоор хийлгүй орхиж маш их үүсмэл орд, овоолго үлдсэн байдаг. Эдгээр хаягдал овоолго дээр орон нутгийн ажилгүй, малгүй иргэд олон жил ашигт малтмал олборлож амь зуулгаа залгуулсаар ирсэн байна. Ийнхүү орон нутгийн иргэдийн олборлолт явуулж байсан талбайд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос газрын төлөөх зөрчил гарах тохиолдол байдаг.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд, тухайн сумын Засаг дарга болон бичил уурхайчдын байгууллага харилцан зөвшилцсөний үндсэн дээр хамтран ажиллах гурван талт гэрээ байгуулж бичил уурхайчдын газрын асуудлыг шийдвэрлэж олборлолт явуулах боломж олгох эрх зүйн зохицуулалт тусгагдсан байдаг. Гурван талт гэрээ байгуулах талаар эцсийн шийдвэр гаргах эрх мэдэл нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талд байдаг тул энэ зохицуулалт амьдрал дээр төдийлөн хэрэгждэггүй байна. Иймээс хувиараа ашигт малтмал олборлогч иргэд, бичил уурхайчид болон уул уурхайн компаниудын хооронд байнга зөрчил гардаг байна. Тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн уурхайн талбай руу дайрах тохиолдол байнга гардгаас компани харуул хамгаалалтаа нэмэгдүүлж, хууль сахиулах байгууллага, цагдаагийн дэмжлэг туслалцаа авдаг. Энэ бүгд компанийн зардлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, улмаар компанийн нэр хүндэд ч муугаар нөлөөлдөг байна. Иймд уул уурхайн компаниуд, бичил уурхайчид хоорондоо яриа хэлэлцээр өрнүүлэн, зөвшилцөлд хүрэх, улмаар хамтарч ажиллах нь аль аль талдаа ашигтай хувилбар юм.

Дор бичил уурхайчид, орон нутгийн удирдлагын удаан хугацааны хүчин чармайлтын үр дүнд талуудын хоорондох зөрчлийг зөргөөр шийдвэрлэсэн сайн туршлагыг та бүхэнд толилуулж байна.



Шигтгээ 1

Манай аймагт 2000 оныг дамнасан зуднаас хойш малгүй болсон иргэд, ажилгүй залуус гээд маш олон хүн бичил уурхай эрхэлж эхэлсэн. Үндсэндээ 2008 оныг хүртэл энэ үйл ажиллагаа маш замбараагүй явагдаж байлаа. Өнөөдрийн арга хэмжээний нэг тал болж оролцож байгаа манай аймгийн "Хувиараа ашигт малтмал эрхлэгч иргэдийг дэмжих холбоо" ТББ нийтдээ 54 нөхөрлөлд 470 гаруй гишүүнтэй. Энэ хүмүүсийг хэн нэгэн хүн зориуд зохион байгуулалттай ийм ажиллагаанд сургаагүй. Амьдрахын эрхэнд төр засгийн дэмжлэг туслалцаагүйгээр орон нутгийн байгалийн баялгийг олборлоод, амьдарлаа залгуулж яваа хүмүүс. Харин хууль журмын хүрээнд зохион байгуулалтад ороод маш идэвхтэй хариуцлагатай болсон. Компанитай, аймаг орон нутгийн зүгээс ч тэр, иргэдийн зүгээс ч тэр гурван жил гаруй яриа, хэлцэл хийсэн. Тэгээд үйл ажиллагаа маань гурван жил дамнаж яригдаж байгаад өнөөдөр манай Спейшл Майнз компани хариуцлагаа ухамсарлаж энэ иргэдийн маань үйл ажиллагааг дэмжиж, өөрийнхөө эзэмшиж буй талбайгаас нийтдээ 2000 орчим тонн хүдэр бүхий

30 га талбайг хоёр жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэр гаргасан.

Орон нутагт хувиараа ашигт малтмал эрхлэгч иргэдийн үүсгэн байгуулсан ТББ, ИТХ, "Спейшл майнз" компанийн хүчин зүтгэл шингэсэн энэхүү хамтын ажиллагааны үзэл санаа амжилттай хэрэгжинэ гэдэгт итгэл төгс байна.



Баянхонгор аймгийн ИТХ-ын дарга Г.Батжаргалын ярилцлагаас. 2012 оны 11 сарын 7, Геологи, уул уурхайн мэдээ сонин.

Баянхонгор аймгийн Баян-овоо сумын нутагт Ц. нэртэй газарт 2004-2005 оноос иргэд хүдэр олборлож эхэлсэн боловч 2007 онд тусгай зөвшөөрөл олгогдсоноор иргэд, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон орон нутгийн захиргаа, хууль сахиулах байгууллагын хооронд зөрчил, маргаан гарах болсон байна. Тус аймгийн Баян-овоо суманд 2008 онд бичил уурхайн олборлолт явуулдаг иргэдийн санаачлагчаар Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо (ХАМОДХ) ТББ байгуулагдсан. Энэ байгууллага үүсгэн байгуулагдсан цагаасаа гишүүн бичил уурхайчдынхаа олборлолтын газрыг албан ёсны болгох, эрх ашгийг нь хамгаалах зорилгоор ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компани болон Ашигт малтмалын газар, Монгол Улсын

Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Ерөнхий сайд, мөн тус аймгаас Улсын Их Хуралд сонгогдсон гишүүд, орон нутгийн удирдлагуудад удаа дараа албан бичиг хүргүүлж, уулзалт, ярилцлага зохион байгуулсны үр дүнд зөвшилцөлд хүрсэн байна.

Улмаар 2012 оны 11 дүгээр сард Спейшл майнз компанитай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, гурвалсан гэрээ байгуулан одоог хүртэл хамтран ажиллаж байна.

Шигтгээ 2

Гранд Колумб Гоулд компани нь Канадад төвтэй, Колумб улсад уул уурхайн үйлдвэрлэл явуулж байгаа алт, мөнгө олборлодог дэлхийн томоохон компаниудын нэг юм. Тус компани уул уурхайн лиценз авахад тухайн уурхайн талбай дээр орон нутгийн 8000 гаруй бичил уурхайчдын 196 хууль бус уурхай ажиллаж байсан. Компани уул уурхайн үйл ажиллагаагаа явуулж эхлэхэд эдгээр хууль бус уурхайд ажиллаж байгаа бичил уурхайчдын эсэргүүцэлтэй тулгарсан байна. Иймээс эдгээр уурхайчдыг зохион байгуулалтад оруулж, хууль бус уурхайнуудыг албажуулахын тулд Хариуцлагатай уул уурхайн холбоо(ARM)-той 5 жилийн турш хамтран ажиллаж байгаа ажээ.

Компанийн зүгээс лицензтэй талбай дээр ажиллаж байгаа хууль бус уурхайчдыг албажуулахын тулд 3 үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Эхлээд эдгээр хууль бус олборлолт явуулж байгаа хүмүүст чиглэсэн сурталчилгаа, ухуулга, нөлөөллийн ажил хийж, тэдгээрийн уурхайн олборлолтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн байна. Дараа нь хийсэн дүн шинжилгээн дээрээ үндэслэн уурхайн төлөвлөгөө боловсруулж, тэдгээр уурхайнуудтай гэрээ байгуулжээ. Бичил уурхайчдын олборлолтын үйл ажиллагаанд оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч 4 төрлийн гэрээ байгуулсан байна. 2015 оны 9-р сарын байдлаар компани 36 гэрээ байгуулан ажиллаж байна. Компани өөрийн хөрөнгөөр уурхай руу орох гурван амтай уурхайн дэд бүтцийг байгуулж, агааржуулалтын систем болон цахилгаан шатнуудыг суурилуулжээ. Компани уурхайг 38 түвшинд хувааж, бичил уурхайчид 1-21 дэх түвшинд олборлолт явуулдаг бол компани 21-38 дахь буюу уурхайн гүнд олборлолт явуулдаг байна. Компани болон бичил уурхайчид олсон ашгаа бичил уурхайчдын оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээнээс


хамаарч хуваадаг бөгөөд бичил уурхайчид компаний дэд бүтцийг үнэ төлбөргүй ашигладаг байна.

Олборлолтын үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийдэггүй буюу уламжлалт аргаар олборлолт явуулдаг бичил уурхайчид орлогын 30%, дунд оврын тоног төхөөрөмж ашигладаг бичил уурхайчид 50%, харин хүнд машин механизм ашигладаг бичил уурхайчид орлогын 70% -ийг авдаг байна.

Гранд Колумб Гоулд компанийн гадаад харилцаа хариуцсан дэд ерөнхийлөгч Жозей Игнасио Ногуротой хийсэн уулзалтын тэмдэглэлээс, Богота хот, 2015 оны 9 сар.

Бичил уурхайчид болон орон нутгийн төрийн удирдлагууд, цагдаагийн байгууллагын хоорондын зөрчил:

Бичил уурхайчид болон орон нутгийн төрийн байгууллагууд, цагдаагийн байгууллагын ажилтнуудын хооронд бичил уурхайн олборлолтын газрын асуудлаас үүдэлтэй зөрчил, тэмцэл гарах тохиолдол байдаг. Бид дор бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газрын асуудлаа орон нутагтайгаа зохицуулсан бичил уурхайчдын туршлагаас дор толилуулъя.



Шигтгээ 3

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Буянтын хөндий Шарын гол ТББ нь 2009 онд 200 гаруй гишүүнтэйгээр үүсгэн байгуулагджээ. Тус ТББ-ын гишүүдийн тоо 2012 он гэхэд 500-д хүрч байсан. 2012 онд тус ТББ-ын гишүүн бичил уурхайчид Буянтын хөндийд 2.8 га газарт тухайн үеийн сумын Засаг даргаас зөвшөөрөл авч албан ёсоор гэрээ байгуулан ажилласан байна. Гэрээний хугацаанд бичил уурхайн нөхөрлөлүүд олборлолт явуулсан Буянтын хөндийн 2.8 га газарт дундын нөхөн сэргээлт хийж 2013 онд орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгчээ. Нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээлгэн өгсний дараа дахин ашигт малтмал олборлох гэрээ байгуулах өргөдөл гаргасан боловч Засаг даргын зүгээс газрын асуудлыг шийдвэрлээгүй байна. Бичил уурхайн нөхөрлөлүүд амь зуулгаа залгуулахын тулд Буянтын хөндийд зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлож эхэлжээ. Холбогдох хууль, журмын дагуу сумын Засаг дарга олборлолт явуулж байгаа газрыг компаний тусгай зөвшөөрөлтэй талбайг чөлөөлөх тухай захирамж гаргажээ.

Захирамжийг хэрэгжүүлэхээр цагдаа, хүчний байгууллагад газар чөлөөлөх үүрэг өгсөн байна. Тиймээс гишүүдийнхээ ажлын байрыг хамгаалах, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газрын асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага гарсан байна. Бичил уурхайчид хүч хэрэглэх эсэргүүцэл, тэмцлээс илүүтэйгээр хуулийн хүрээнд өөрсдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг явуулжээ. Газар чөлөөлөх үүрэг гүйцэтгэхээр ирсэн цагдаагийн бие бүрэлдэхүүн, сумын удирдлагаас бичил уурхайчид өөрсдийн эрхийг шаардаж, өөрсдийн үйл ажиллагааг зөвөөр ойлгуулж, өөрсдийгөө хариуцлагатай уул уурхай эрхэлж чадах чадвартай гэдгээ таниулж, үр дүнтэй нөлөөллийн ажил хийж чадсанаар олборлолтын үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хийх боломжтой болсон байна.



Бичил уурхайчдын сайн туршлага, 2014 он

Дээрх жишээ бичил уурхайчид эвлэлдэн нэгдэж зохион байгуулалттайгаар дуу хоолой, үзэл бодлоо аймаг, орон нутгийн удирдлага, шийдвэр гаргагч нарт хүргэх, өөрсдийн бодит байдлыг тайлбарлан таниулах, эрхээ шаардах чадавхтай байх нь орон нутгийн төрийн захиргааны байгууллага, түүний удирдлага, хууль сахиулах байгууллагын ажилтнуудтай зөрчилдөх, үл ойлголцохоос урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

Түүнчлэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төр, захиргааны байгууллага, албан тушаалтанд албан бичгээр ажлын байраа баталгаажуулах талаар өргөдөл, хүсэлт гаргах, түүнийхээ хариуг хуулийн хугацаанд шаардах зэргээр эрхээ шаардсан нь тухайн зөрчлийг шийдвэрлэх маш оновчтой арга зам байсан юм.

Шигтгээ 4

Колумб Улсын Сантандер мужийн Ветас тосгон уламжлалт уул уурхайн үйл ажиллагаа хөгжсөн газрын нэг юм. Энэ тосгоны бичил уурхайчид хоршоо байгуулан хариуцлагатай олборлолт явуулдаг бөгөөд Шударга олборлолтын гэрчилгээ авахаар ажиллаж байгаа ажээ. Бичил уурхайчдын олборлолт явуулдаг алтны үндсэн орд газар нь эко системийн эрсдэлтэй газар нутгийн хил дээр оршдог байна. Хэдийгээр Колумбын Засгийн газар байгаль орчныг хамгаалах шинэ багц хуулийг

хэрэгжүүлж эхэлснээр ойн болон усны ундарга бүхий газарт ашигт малтмал олборлохыг хориглож байгаа боловч энэ тосгоны бичил уурхайчид ашигт малтмал олборлох эрхтэй юм. Бичил уурхайчдын хяналтгүй мөнгөн усны хэрэглээг зохицуулах зорилгоор уурхайн талбай дээр нь гравитацийн аргаар хүдэр баяжуулах үйлдвэр байгуулжээ.

Баяжуулах үйлдвэрээс гарч буй усыг цэвэршүүлэн гол руу нийлүүлдэг бөгөөд байгаль орчны байцаагч сар бүр ирж усны дээжинд шинжилгээ хийдэг байна. Орон нутгаас авч хэрэгжүүлсэн шат дараалсан арга хэмжээний үр дүнд бичил уурхайчид мөнгөн ус хэрэглэхээс зайлсхийдэг болжээ. Баяжуулах үйлдвэрийн алт барилт нь 80 хувьтай байдаг бөгөөд баяжуулахаас гарсан хаягдалд агуулагдаж буй алтыг гүйцээн бариулахын тулд байгальд хор нөлөөгүй гэж тооцогддог цианитаар хөвүүлэн баяжуулах технологиор хаягдлыг боловсруулдаг байна. Ветасын удирдлагууд сүүлийн жилүүдэд бичил уурхай зохицуулах, албажуулахад чиглэсэн үйл ажиллагаагаа эрчимжүүлж байгаа ажээ.

Колумб улсын бичил уурхайн талаар туршлага судлах арга хэмжээний тайлан, ТБУТ, 2015 он.



Манай орны дархан цаазтай газар нутаг болон орон нутгийн тусгай хамгаалалттай газарт иргэд хувиараа ашигт малтмал олборлож байгаагаас шалтгаалан орон нутгийн удирдлагууд, иргэдийн хооронд зөрчил гардаг. Эдгээр газар нутагт ашигт малтмал олборлохыг хуулиар хориглодог учир орон нутгаас цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хууль бус ашигт малтмал олборлогчдыг хөөж туух, багаж төхөөрөмжийг нь хураах зэргээр үйл ажиллагааг нь таслан зогсоохыг оролддог. Гэсэн хэдий ч энэ арга хэмжээ нь эцэстээ төсвийн мөнгө их хэмжээгээр үрэгдэх, иргэд, орон нутгийн төрийн байгууллага болон цагдаагийн байгууллагын ажилтнуудын хооронд зөрчил тэмцэл үүсэх, улмаар хүний эрхийн ноцтой зөрчил гарахад хүргэх тохиолдол байдаг ч хууль бус олборлолтыг зогсоож, асуудлыг шийдвэрлэж чаддаггүй. Иймд Колумбын Ветас тосгоны туршлагаар нутгийн иргэд олон жилээр ашигт малтмал олборлож байгаа боловч дархан цаазтай, тусгай хамгаалалтад эсвэл тусгай хэрэгцээнд байгаа зарим газар нутагт мэргэжлийн хяналтын байгууллагын нарийн хяналтын дор ашигт малтмал олборлох тухай шийдвэрийг эрх бүхий байгууллага гаргаж шийдвэрлэх юм.

Хоёрдугаар бүлэг. Өргөдөл, гомдол, түүнийг шийдвэрлэх нь

2.1. Өргөдөл, гомдлын талаарх ерөнхий ойлголт



Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалтад Монгол Улсын иргэн “Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэж иргэний өргөдөл, гомдол гаргах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан бөгөөд Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч аль ч төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй.

Улсын Их Хурлаас 1995 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл,

гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар өргөдөл, гомдол гэж юуг хэлэх вэ, өргөдөл, гомдол гаргах зарчим, хэлбэр, өргөдөл, гомдолд тавигдах шаардлага, өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, хариу өгөх, өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх нийтлэг үүрэг зэрэг асуудлыг зохицуулдаг.

Өргөдөл, гомдол гаргах нь ямар нэг асуудлыг дэвшүүлж зохих байгууллагаар шийдвэрлүүлж буй хэрэг бөгөөд ердийн харилцаанд тэднийг төдийлөн зааглаж хэрэглэдэггүй боловч зориулалт, ач холбогдол, нэршлийн хувьд ялгаатай юм.

Дээрх хуульд зааснаар “аливаа асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж, хувь хүнээс гаргаж байгаа хүсэлтийг өргөдөл гэнэ”, “төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь иргэдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд энэхүү зөрчлийг арилгуулахаар зохих байгууллагад хандаж гаргасан хүсэлтийг гомдол гэнэ” гэж тус тус тодорхойлжээ.

Өөрөөр хэлбэл өргөдөл нь хувь хүн, хувийн байгууллагаас асуудал шийдэхээр газар, албан тушаалтан нарт хувийн хүсэлтээ бичин өргөж байгаа албан бичиг юм. Гэхдээ энэ нь аль нэг байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд гомдолтой буйгаа илэрхийлсэн шинж агуулаагүй байх ёстой.

Өргөдөл нь дотроо саналын эсвэл мэдэгдлийн шинжтэй байж болно.

Мэдэгдлийн шинжтэй өргөдөл нь амьдралд хамгийн их хэрэглэгддэг бөгөөд аливаа асуудлыг шийдвэрлүүлэх тухай агуулгатай байна. Харин саналын шинжтэй өргөдөл нь аль нэг байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд холбогдуулан, түүнийг засаж, сайжруулах, шинэчлэх агуулгатай байна.

Гомдол нь төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт бөгөөд аль нэг байгууллага, албан тушаалтнаас явуулж буй үйл ажиллагаа таны эрх, ашиг сонирхолд нийцэхгүй, зөрчиж байна гэж үзвэл энэ тухайд гомдолтой байгаагаа илэрхийлэх албан бичгийн төрөл юм.

Өргөдөл, гомдол гаргах хэлбэр:

Өргөдөл, гомдлыг төрийн албан ёсны хэл буюу монгол хэлээр гаргах бөгөөд монгол хэл мэдэхгүй бол төрөлх хэлээрээ гаргаж болно. Өргөдөл, гомдлыг дараах хэлбэрээр гаргана.

- бичгээр
- амаар
- цахим сүлжээгээр дамжуулан

Амаар биечлэн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч байгаа этгээд тэмдэглэн авч, өргөдөл, гомдол гаргагчийн гарын үсгийг зуруулна. Гарын үсгээ зурж чадахгүй бол энэ тухай тэмдэглэнэ.

Мөн иргэд радио, телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр болон тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан өргөдөл, гомдол гаргаж болно.

Өргөдөл, гомдолд тавих шаардлага:

Өргөдөл, гомдол гаргагч өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулийг зөрчих, бусдын эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, ялгаварлан гадуурхахыг уриалж болохгүй бөгөөд тухайн өргөдөл, гомдол нь үнэн зөв байх ёстой.

Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд овог, нэр оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурах бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зуруулж болно.

Өргөдөл үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж, утсаар дамжуулан өргөдөл, гомдол гаргаж болно. Гарын үсгээ зурах, нотлох баримт бичгийг хавсаргасан байна.

Өргөдөлд холбогдох баримт бичгийг хавсаргаж, гарын үсгээ зурсан байх бөгөөд бага насны хүмүүс буюу шүүхийн шийдвэрээр эрхийн бүрэн чадамжгүйд тооцогдсон этгээд эцэг, эх, асран хамгаалагчаараа төлөөлүүлээгүй бол, төрийн тухайн байгууллага, албан тушаалтанд иргэн өмнө нь хандаж байсан асуудлаар өргөдөл, гомдол гаргасан бөгөөд түүнийг дахин хянаж шийдвэрлэх үндэслэлгүй, өргөдөл тухайн байгууллага, албан тушаалтанд иргэн өмнө нь хандаж байсан тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтан өргөдөл байгууллага хянан үзэлгүйгээр буцаахаар хуульд заасан байдаг.

Иймээс өргөдөл, гомдолд тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна түүнд дурдсан үйл баримт нь үнэн, дэс дараатай, ойлгомжтой, юу хүссэн нь тодорхой байхыг анхаарах нь зүйтэй юм.

/Загвар/

**Хандаж байгаа байгууллага,
албан тушаалтны нэр**

Өргөдөл, гомдлын товч утга

Агуулга:

- **Өргөдөл, гомдол гаргагчийн товч танилцуулга**
- **Шийдвэрлүүлэхийг хүсч буй асуудал**

**Өргөдөл, гомдол гаргагчийн оршин
суух газрын хаяг, овог, нэр,
гарын үсэг**

Он.сар.өдөр

Өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацаа: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлд төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн 30 хоногоор сунгана.

2.2. Өргөдөл, гомдлоо хэнд гаргах вэ?

Өргөдөл, гомдол барагдуулах механизм нь төрийн болон төрийн бус, шүүхийн болон шүүхийн бус арга замаар дамжуулан төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлийн талаарх өргөдөл, гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх үе шат болон зөрчигдсөн эрхийг сэргээх цогц үйл ажиллагааг ойлгоно.

Өргөдөл, гомдол барагдуулах төрийн механизмыг засгийн газрын байгууллагууд, хууль тогтоомж эсвэл Үндсэн хуулиар эрх олгогдсон төрийн эрх бүхий бие даасан байгууллага хэрэгжүүлдэг. Тухайлбал Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, Шүүх, Хүний эрхийн Үндэсний Комисс, орон нутгийн засаг захиргааны байгууллага, Прокурорын байгууллага, Цагдаагийн байгууллага болон бусад төрийн



байгууллагууд иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн тухай өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэдэг.

Өргөдөл, гомдол гаргагч нь хуульд заасан хугацаанд өргөдөл, гомдлыг шийдвэрлээгүй эрх бүхий байгууллага, албан тушаалтын талаар болон шийдвэрлэлт нь хуулийн үндэслэлгүй гэж үзэж зөвшөөрөөгүй тохиолдолд энэ тухай гомдлоо тухайн захиргааны актыг гаргасан байгууллага, албан тушаалтны дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд, дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол тухайн захиргааны актыг гаргасан байгууллагад, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргана.

2.2.1. Монгол Улсын Их Хурал

Монгол Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.²

Улсын Их Хуралд гаргах өргөдөл, гомдлыг өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнд, холбогдох байнгын хороодод болон Улсын Их Хурлын Тамгын газраар дамжуулан гаргаж болно.

²Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл. 1992 он.

Улсын Их хурлын тухай хуульд зааснаар Улсын Их Хурлын гишүүн нь иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэж хариуг нь шууд өгөх, эсхүл хариуцан шийдвэрлэх эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлж энэ тухай хариу мэдэгдэх бөгөөд гишүүнээс шилжүүлсэн өргөдөл, гомдол болон хууль тогтоомжийн хэрэгжилт, бусад асуудлаар ирүүлсэн албан бичгийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан нь 30 хоногийн хугацаанд асуудлыг шийдвэрлэж хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэй.

УИХ нь дотроо тодорхой асуудал хариуцсан байнгын хороодод хуваагдан ажиллах ба УИХ-ын гишүүн нь ямар нэгэн байнгын хороонд заавал харьяалагддаг. Иргэд гаргаж буй өргөдөл, гомдлоо асуудлаас нь хамааруулан холбогдох байнгын хороо, байнгын хорооны гишүүдэд гаргаж болно.

УИХ нь хууль тогтоох үндсэн чиг үүрэгтэй байгууллага тул иргэд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох чиглэлээр өргөдөл, санал, хүсэлт гаргах боломжтой.

УИХ-аас 2012 онд Монгол Улсын Их хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Өргөдлийн байнгын хороог анх байгуулжээ.

Өргөдлийн байнгын хороо хуульд заасны дагуу УИХ, түүний Байнгын болон дэд, түр хороо, тэдгээрийн удирдлагад ирүүлсэн өргөдлийг судалж, шийдвэрлэх үүрэгтэй. Өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох, холбогдох албан тушаалтнаас тайлбар авах бүрэн эрхтэй байна. Өргөдлийн байнгын хороо иргэдийн өргөдөлд үндэслэн нийгэмд тулгарч байгаа бэрхшээл, асуудлыг илрүүлэх, түүнийг шийдвэрлэх зорилготой ажилладаг. Мөн хууль тогтоох үйл ажиллагаанд иргэний оролцоог дэмжих, шууд ардчиллыг нэвтрүүлэх, хуулийн биелэлтэд иргэдтэй хамтарч хяналт тавих боломжийг бүрдүүлэн ажилладаг. Өргөдлийн дагуу Өргөдлийн байнгын хорооноос дараах үйл ажиллагаа явуулна:

- Өргөдлийг үндэслэн нээлттэй сонсгол зохион байгуулах;
- Өргөдлийг нарийвчлан судалж, шийдвэрлэх Ажлын хэсэг байгуулах;
- Хууль санаачлах эрхтэй субъектэд хууль санаачлуулахаар хүргүүлэх;
- УИХ-аар шийдвэр гаргуулахаар зөвлөмж гаргах, УИХ-ын тогтоолын төслийг бэлтгэх;

- Хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газар, холбогдох байгууллага, албан тушаалтанд албан шаардлага, даалгавар, мэдэгдэл, зөвлөмж өгөх;
- Өргөдөлд дурдсан асуудал нь хуулиар бусад байгууллага, албан тушаалтны бүрэн эрхэд харьяалагдахаар бол холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

УИХ-ын хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа, санхүү, аж ахуйн үйлчилгээ үзүүлэх зорилготой Тамгын газар ажилладаг. УИХ-ын Тамгын газар нь УИХ-д иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлүүлэх арга хэмжээ авах үүрэгтэй байгууллага юм.

Мөн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаа, нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн нутаг дэвсгэр дэх захиргааны хэм хэмжээний актыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл түүнд хяналт тавих асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах хүсэлтээ Улсын Их Хуралд хандаж гаргах боломжтой байна.

Энэхүү хүсэлтийг гаргахдаа овог, нэр оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурсан байх ба өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа тухай болон сонсголыг зохион байгуулах үндэслэл, шаардлагыг тодорхой дурдсан байна.

Иргэдээс УИХ-н Өргөдлийн байнгын хороонд өргөдөл, гомдол гаргахдаа Тамгын газрын иргэд хүлээн авах ажилтанд хандан амаар /Сүхбаатар дүүрэг, Төрийн ордны чанх ард байрлах/ болон бичгээр гомдол гаргахаас гадна төрийн үйлчилгээний цэг /ТҮЦ/ машинаар дамжуулан, мөн www.urgudul.parliament.mn хаягаар цахим хэлбэрээр гаргах боломжтой байна.

2.2.2. Засгийн газар, яам, агентлаг

Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх дээд байгууллага юм.³

Иргэд өргөдөл, гомдол гаргахдаа тухайн асуудалд холбогдох яамдуудыг зөв сонгож, тухайн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хандах нь зүйтэй.

Засгийн газар нь өөрийн шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг зохицуулахад туслах, нийтлэг үйлчилгээний удирдлагаар хангах асуудлыг эрхлэн гүйцэтгэх Хэрэг эрхлэх газартай байдаг.

Иргэдээс Засгийн газар, Ерөнхий сайд, Шадар сайдад хандаж, өргөдөл, хүсэлт гаргахаар бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар дамжуулна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар эсхүл холбогдох хэлтэст болон асуудал хариуцсан албан тушаалтанд хаяглаж ирүүлнэ.

Харин яамд, агентлагуудтай холбоотой асуудлаар өргөдөл гомдол гаргахаар бол тухайн яам, агентлаг түүний хэлтэс, газарт эсвэл албан тушаалтанд шууд хаяглаж явуулах нь цаг хугацаа алдахгүй байх боломжийг олгоно. Учир нь Засгийн газарт ирж буй өргөдөл, гомдлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт бүртгэж, хянаж үзээд тухайн асуудалд холбоотой яамд, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд шилжүүлдэг.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, удирдах үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцдаг.

2.2.3. Орон нутгийн засаг захиргааны байгууллага

Иргэд шаардлагатай тохиолдолд өөрт тулгарсан асуудлаа шуурхай, хүндрэлгүй шийдвэрлүүлэхийн тулд өөрт хамгийн ойр харьяалах шатны орон нутгийн засаг захиргааны байгууллагадаа ханддаг.

Монгол Улс нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагддаг бөгөөд манай улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгждэг.

³Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйл, 1992 он

Захиргааны ерөнхий хуулиар⁴ нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлжээ.

Уг хуульд зааснаар нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгох ба төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага⁵, нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага⁶ тус тус хамаарахаар заасан байна.

Өөрөөр хэлбэл төв, орон нутгийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн болон Иргэдийн нийтийн хурал нь захиргааны байгууллага гэж үзнэ.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь дөрвөн жил тутамд нутгийн иргэдээс сонгогддог ба аймаг, нийслэл, сум, дүүрэгт Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ), баг, хороонд Иргэдийн Нийтийн Хурал (ИНХ) юм.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд Иргэн та өөрийн тойргоос сонгогдсон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид хандаж өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлж болохоос гадна баг, хорооныхоо Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар аливаа асуудлыг шийдвэрлэхэд биечлэн оролцох боломжтой юм.

Иймээс иргэн, хуулийн этгээд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл дээрх захиргааны байгууллагын гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журам буюу захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэхийг хянуулахаар тухайн захиргааны актыг гаргасан байгууллагын дээд шатны захиргааны байгууллагад, эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гомдол гаргах эрхтэй⁷ байна.

⁴Захиргааны ерөнхий хууль. 2015 он.

⁵Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэг, 2015 он.

⁶Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь хэсэг, 2015 он.

⁷Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйл, 2015 он.

Захиргааны байгууллага нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүлээн авч, хуульд өөрөөр заагаагүй бол 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө.

ИТХ-ын хуралд өргөдөл, гомдол гаргахдаа дараах байдлаар хандаж болно.

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд
2. Өөрийн тойргоос сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчид
3. ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргад
4. ИТХ-ын Тэргүүлэгчид

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь ажлын албатай байх ба түүнийг нь Тамгын газар гэдэг. Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас тогтооно. Засаг даргын Тамгын газар нь дотроо хэлтсүүдэд хуваагдах ба бичиг хэрэг хариуцсан хэлтэс, албан тушаалтан иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авна. Ихэнх орон нутгийн захиргааны байгууллагууд иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах хайрцгийг байрлуулсан байдаг.

Засаг даргад гаргах өргөдөл, гомдлыг түүний Тамгын газраар дамжуулан тавих нь зохимжтой юм. Харьяа байгууллага, хороодод иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн тухай мэдээ, тайланг Тамгын газрын Иргэдийн санал, өргөдөл, гомдлын асуудал хариуцсан зохион байгуулагч улирал бүр авч нэгтгэн дүгнэлт хийж Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулах ба дээд шатны Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх үүрэгтэй байдаг.

Иргэдийн гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэл хяналтын картанд биелэлтийг тэмдэглэн бүртгэлийн дугаараар архивын нэгж болгон хадгалдаг тул иргэд өөрсдийн өмнө нь хэнд, хэзээ, юуг хүсэж, ямар асуудлыг шийдвэрлүүлэхээр гаргаж байсан өргөдөл, гомдлын талаарх мэдээлэл, баримтыг шаардлагатай тохиолдолд тухайн байгууллагын архиваас гаргуулан авах боломжтой байдаг.

2.2.4. Шүүх

“Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”⁸ гэж заасан бөгөөд шүүх нь хүний эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлдэг байгууллага юм.

⁸Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйл, 1992 он

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван тавдугаар зүйлд "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", "...Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл иргэн нь шүүхэд гомдол гаргах ... эрхтэй..." хэмээн заасан бөгөөд үүнээс үзэхэд иргэн хүний хувьд чухам өөрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол гэж юу болохыг мэдэх шаардлагатай юм.

Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум, сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эдгээр шүүхүүд нь эрүү, иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг. Үүнээс гадна Үндсэн хуульд шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүх байгуулж болно гэж заасны дагуу 2002 онд Захиргааны хэргийн шүүхийн тухай хуулийг баталж, 2004 оноос захиргааны хэргийн шүүх байгуулагдан ажиллаж байна.

Шүүх нь шийдвэрлэж буй хэрэг маргаан, шүүн таслах ажиллагааны онцлог зэргээс хамаарч хоорондоо ялгагддаг. Тухайлбал иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хоорондын маргааныг иргэний хэргийн шүүх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэх асуудал болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг эрүүгийн хэргийн шүүх хянан шийдвэрлэдэг бол захиргааны байгууллага, албан тушаалтны хууль зөрчсөн захирамж, тогтоол, шийдвэрийг хүчингүй болгох, учирсан хохирлыг арилгуулах асуудлыг захиргааны хэргийн шүүх тус тус шийдвэрлэдэг.



Иргэний болон эрүүгийн хэргийн шүүх:

Хүн бүр өдөр тутам нийгмийн харилцаанд оролцож байдаг бөгөөд гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, дутуу биелүүлэх, гэрээг буруу ойлгох, бусдад гэм хор учруулах, ажил гүйцэтгэх, түрээс, өв залгамжлал болон гэрээслэл, эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотойгоор иргэд-иргэд хооронд, иргэд-хуулийн этгээд, хуулийн этгээд-хуулийн этгээд хооронд үл ойлголцол үүсэх, маргах тохиолдол цөөнгүй гардаг тул уг маргаж буй асуудлаа өөр хоорондоо эв зүйгээр шийдвэрлэх боломжгүй тохиолдолд иргэний журмаар шүүхэд хандаж шийдвэрлүүлдэг.

Иргэний хэргийн шүүх дараах маргаантай холбоотой асуудлыг хянан шийдвэрлэнэ:

- Эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл / бүх төрлийн гэрээний маргаан, нэр төр, алдар хүндэд учирсан гэмт хорын хохирол гаргуулах гэх мэт зөрчигдсэн эрхээ сэргээлгэхтэй холбоотой асуудлууд гэх мэт/
- Бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл/ тухайлбал Хүний эрхийн Үндэсний Комисс эрх нь зөрчигдсэн иргэнийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хуулиар олгогдсон байдаг/
- Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт /төрснийг болон нас тогтоолгох, ажилласан жил тогтоолгох, үрчлэлтийг хүчингүй болгох, иргэнийг сураггүй алга болсон болон нас барсанд тооцуулах, гэх мэт/

Харин эрүүгийн хэргийн шүүхийн хувьд гэмт хэрэгт холбогдсон хүнийг гэмт хэрэг үйлдсэн эсэх, гэм буруутай эсэх асуудлыг хянан шийдвэрлэж, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүнд эрүүгийн хуульд заасан ял шийтгэл ногдуулах болон гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэдэг.

Иргэний шүүхэд нэхэмжлэл гаргах ерөнхий болон тусгай хөөн хэлэлцэх хугацаа байна. Ерөнхий хөөн хэлэлцэх хугацаа нь 10 жил байна. Тусгай хөөн хэлэлцэх хугацааг хүснэгтээс харна уу.

Иргэний маргаан	Хөөн хэлэлцэх хугацаа
Гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хугацаа	3 жил
Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой шаардлага гаргах хугацаа	6 жил
Гүйцэтгэх үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хугацаа	3 жил
Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулснаас үүсэх үүрэгтэй холбоотой	5 жил

Дээрх хөөн хэлэлцэх хугацаанд шүүхэд нэхэмжлэл гаргах бөгөөд уг хугацаа дууссан тохиолдолд нэхэмжлэл гаргах хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг өөрийн харьяалах иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргана.

Захиргааны хэргийн шүүх:

Захиргааны хэргийн шүүх 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс байгуулагдсан бөгөөд харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжээс хамааран аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх, Улсын дээд шүүхэд захиргааны хэргийн танхим байгуулагдан ажиллаж байна. Иргэн, хуулийн этгээдээс Захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан аливаа эрх зүйн акт, шийдвэрийг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хууль ёсны эрх ашгаа хамгаалуулахаар хариуцагчийн оршин байгаа газрын харьяалах захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах бөгөөд энэхүү харилцааг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна. Өөрөөр хэлбэл төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан аливаа тушаал, шийдвэр, тогтоол, захирамж нь хууль зөрчсөн бол түүнийг хүчингүй болгуулахаар захиргааны хэргийн шүүхэд ханддаг.

Захиргааны хэргийн шүүх дараах маргааныг харьяалан шийдвэрлэнэ:

- Монгол Улсын Засгийн газрын гишүүн /Ерөнхий сайд, сайд/,
- Монгол Улсын яам,
- Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг,
- Төрийн албаны Зөвлөл, түүний салбар байгууллага,
- Монголбанк,
- Санхүүгийн зохицуулах хороо,
- Яамны харьяа болон харьяа бус захиргааны акт гаргадаг бие даасан агентлаг, түүнтэй адилтгах газар, зөвлөл, товчоо, төв, сан зэрэг байгууллага,

- Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга,
- Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг /хэлтэс, газар/,
- Улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагч,
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчдийн гаргасан захиргааны акт нь захиргааны хэргийн шүүхэд хамаарна.

Хуульд өөрөөр заагаагүй захиргааны үйл ажиллагаанд гомдол гаргах ажиллагаа Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу явагдсан бол дараах тохиолдолд шийдвэрийг мэдэгдсэнээс хойш захиргааны хэргийн шүүхэд 30 хоногийн дотор нэхэмжлэл гаргана.

Нэхэмжлэл гаргах:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар “Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гаргасан өргөдөл, хүсэлт, гомдлыг иргэний хэргийн нэхэмжлэл гэдэг.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь хэсэгт зааснаар “нэхэмжлэл” гэдэг нь иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны сонирхлоо хамгаалуулахаар Захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийг хэлнэ.

Иргэдийн дунд шүүхэд нэхэмжлэлд гаргахдаа нэхэмжлэлд тавигдах нөхцөл, шаардлагыг хангаагүй, нэхэмжлэл болон нэхэмжлэлийн шаардлагаа буруу тодорхойлсноос цаг хугацаа алдах тохиолдол элбэг байдаг.

Тиймээс шүүхэд гаргах нэхэмжлэлд дараах зүйлийг заавал тусгана.

- Нэхэмжлэлийг аль шүүхэд гаргаж байгаа
- Нэхэмжлэгчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол нэр, оршин байгаа газрын хаяг
- Хариуцагчийн нэр, оршин байгаа газрын хаяг
- Нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг тодорхой зааж өгсөн байх ба агуулга тодорхой бус тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас

татгалзах, нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа зааж буцаах зэрэг ажиллагаа явагддаг тул нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг тодорхой бичих/

- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл чөлөөлөгдөх хүсэлт, түүнийг нотлох баримт /эд хөрөнгөтэй холбоотой нэхэмжлэлд маргаж байгаа эд хөрөнгийн үнийн дүнгийн тодорхой хувиар, эдийн бус хөрөнгөтэй холбоотой нэхэмжлэлд 70,200 төгрөгийг харьяалах татварын байгууллагын дансанд тушаана./
- Хавсаргасан баримт бичгийн жагсаалт /маргаан бүхий захиргааны акт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдол бүхий нотлох баримт, итгэмжлэл гэх мэт /
- Нэхэмжлэлд нэхэмжлэгч гарын үсэг зурсан байна.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллага аливаа эрх зүйн маргаанаа шүүхээр хянан шийдвэрлүүлэхийн улсын тэмдэгтийн хураамж төлөх бөгөөд эд хөрөнгийн чанартай үнэлж болох нэхэмжлэлд нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж төлдөг.

Нэхэмжлэлийн үнийн дүн /төгрөгөөр/	Хураамжийн хувь, хэмжээ /төгрөгөөр/
0-130 000	4550 төгрөг.
130 001-650 000	4550 төгрөг дээр 130 000 төгрөгөөс давсан дүнгийн 3 хувийг нэмнэ.
650 001-1 300 000	20150 төгрөг дээр 650 000 төгрөгөөс давсан дүнгийн 2.4 хувийг нэмнэ.
1 300 001-13 000 000	35750 төгрөг дээр 1 300 000 төгрөгөөс давсан дүнгийн 1.6 хувийг нэмнэ.
13 000 001-ээс дээш	222950 төгрөг дээр 13 000 000 төгрөгөөс давсан дүнгийн 0.5 хувийг нэмнэ.

Харин эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэл гаргахад тэмдэгтийн хураамж 70 200 төгрөгийг төлнө.

Мөн шүүхээс хуульд заасны дагуу өргөдөл, гомдол, нэхэмжлэл гаргагчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан хураамж төлөх хугацааг хойшлуулж, тэднийг хураамжаас чөлөөлөх буюу төлөх хураамжийн хэмжээг багасгаж болно.

Нэхэмжлэл гаргах загвар

..... **шүүхэд нэхэмжлэл гаргах нь:**
/харьяалах шүүхийн нэрийг тодорхой бичнэ/

20... оны... сарын... өдөр

Нэхэмжлэгч: Ургийн овог, овог, нэр

Гэрийн хаяг /хуулийн этгээд аж ахуйн нэгж бол нэр хаягийг тодорхой бичих/

Холбогдох утасны дугаар:.....

Хариуцагч: ургийн овог, овог, нэр

Хаяг: /ажлын газрын хаяг/, хаана ямар албан тушаал эрхэлдэг болохыг тодорхой бичих/

Холбогдох утасны дугаар:

Ажлын газрын утас.....

Нэхэмжлэлийн шаардлага: /Нэхэмжлэлийн утга, агуулгыг тодорхой бичнэ/

.....
.....
.....

Нэхэмжлэлд хавсаргасан материал:

1. Нэхэмжлэл /2 хувь/

2. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /1 хувь /гэх мэт

3.

Нэхэмжлэл гаргасан...../..... /
/гарын үсэг/ /нэр/

2.2.5. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

Комисс нь Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих байгууллага юм.⁹

⁹Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг. 2001 он.



ХЭҮК-т ямар гомдол харьяалах вэ?

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд зааснаар Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн тухай гомдлыг Комисс хүлээн авна. Харин дараах гомдол Комиссын харьяалалд хамаарахгүй.

- Хэрэг бүртгэл, шүүхийн шатанд болон шүүхээр шийдвэрлэсэн эрүү, иргэний хэрэг маргаантай холбоотой гомдол;
- Хувь хүмүүсийн хоорондын зан харилцааны асуудлаарх гомдол;
- Харьяалах албан тушаалтан шууд шийдвэрлэх боломжтой асуудлаар гаргасан гомдол.

ХЭҮК-т хэн гомдол гаргаж болох вэ?

- Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч;
- Хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
- Иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй, зарим буюу хэсэгчилсэн чадамжтай хүнийг түүний хууль ёсны төлөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч нь төлөөлж;
- Сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүнийг хуульд заасан төлөөлөгч нь төлөөлж;
- Төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллага төлөөлөгчөөрөө дамжуулж тус тус гомдол гаргана.

ХЭҮК-т хэрхэн гомдол гаргах вэ?

Гомдол гаргагч эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн өдрөөс, эсхүл тийнхүү зөрчигдсэн гэдгийг мэдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор гомдол гаргана.

Гомдлыг монгол хэл дээр бичгээр болон амаар гаргана. Монгол хэл мэдэхгүй этгээд эх хэлээрээ гомдол гаргаж болох бөгөөд гомдлоо Монгол хэлнээ орчуулж, зохих журмаар баталгаажуулсан байна.

Хүний эрхийн Үндэсний Комисст гаргах гомдол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Гомдолд дурдагдсан асуудлыг шийдвэрлэх эрх бүхий захиргааны байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлсэн байх;
- Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжид заасан ямар эрх зөрчигдсэн болохыг тодорхой заах;
- Комисст тавьж буй асуудал тодорхой, ойлгомжтой байх;
- Гомдол гаргагч өөрийн нэр, оршин суугаа газрын болон шуудангийн хаяг, утасны дугаараа бичиж, гарын үсгээ зурсан байх;
- Гомдолд холбогдож буй аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний нэр, хаяг, утасны дугаарыг бичих;
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн нөхцөл байдлыг нотлохуйц хууль зүйн хүчин төгөлдөр баримт бичгийг өргөдөл, гомдолдоо хавсаргасан байх /хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд өргөдөл гомдлын бүрдүүлбэрийг хангахад Комисс туслалцаа үзүүлж болно/

Комисс гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хариу өгнө. Нэмэлт судалгаа, шалгалт хийх шаардлагатай гэж үзвэл хугацааг Комиссын дарга 60 хүртэл хоног сунгаж болно.

Комиссын бүрэн эрхэд хамаарах хүний эрх, эрх чөлөө зөрчигдсэн тухай гомдлын мөрөөр шалгалт зохион байгуулна. Комиссын гишүүний гомдлын мөрөөр шалгалт зохион байгуулахтай холбогдсон бүрэн эрхийг "Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль"-ийн 16 дугаар зүйлд заасан байдаг. Тухайлбал, гомдолд холбогдсон албан тушаалтан, бусад эрх мэдэл бүхий хүнийг дуудан ирүүлж бичгээр тайлбар, тодорхойлолт авах, гомдолтой холбоотой асуудлаар аль ч байгууллагад саадгүй нэвтрэн, хурал зөвлөгөөнд оролцох буюу эрх бүхий хүмүүстэй биечлэн уулзах, холбогдох материалтай танилцах, шаардлагатай бол шинжээч томилж дүгнэлт гаргуулах зэрэг бүрэн эрхийг эдэлдэг.

Шалгалтаар хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн буюу зөрчигдөж болзошгүй нь тогтоогдвол дараах арга хэмжээний аль тохирохыг авна.

- Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, эсхүл зөрчих нөхцөл бүрдүүлсэн үйл ажиллагааг зогсоохыг байгууллага, албан тушаалтнаас шаардах буюу зөвлөх;
- Талуудыг эвлэрүүлэх, зуучлах замаар асуудлыг шийдвэрлэх
- Хүний эрх, эрх чөлөө зөрчсөн гэж үзсэн албан тушаалтанд захиргааны шийтгэл ногдуулах тухай хүсэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;
- Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний эрх, эрх чөлөө зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах;
- Гомдол үндэслэлгүй гэж үзвэл гомдол гаргагчид буцаах.

Комиссын гишүүн нь гомдлыг хянан шийдвэрлэсний үр дүнг гомдол гаргагчид мэдэгдэнэ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлд Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж, түүний эрх зүйн үр дагаврын талаар заасан. Комиссын гишүүн нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл шаардлага, хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй гэж үзсэн тохиолдолд эрх хэмжээний хүрээнд зөвлөмж гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Комиссын гишүүний шаардлагыг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан долоо хоногийн дотор, зөвлөмжийг хүлээн авсан бол гуч хоногийн дотор авсан арга хэмжээнийхээ тухай бичгээр хариу мэдэгдэх үүрэг хүлээдэг.

Харин Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авахаас татгалзсан аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтны талаар хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж болно.

Мөн Нийтийн сонсголын тухай хуульд захиргааны хэм хэмжээний актыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг явуулах талаар иргэн иргэн, хуулийн этгээдээс хүсэлт гаргаж болох бөгөөд хүний эрхийн асуудлаар ерөнхий хяналтын

сонсгол явуулах бол Хүний эрхийн Үндэсний Комиссоор дүгнэлт гаргуулж болно.

ХЭҮК-т амаар болон бичгээр гомдол гаргахаас гадна <http://www.mn-nhrc.org/index.php?do=static&page=1> цахим хаяг дахь "Гомдол гаргах" хэсэгт хандаж цахим хэлбэрээр гомдол гаргах боломжтой.

Мөн 70000-222, 51-262971 дугаарын утсаар иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авч, хууль зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

2.2.6. Прокурорын байгууллага

Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн.¹⁰

Прокурорын байгууллага нь дараах тохиолдолд иргэн таны өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч, хянан шийдвэрлэнэ. Үүнд:

- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу иргэн, хуулийн этгээд, прокурор, ажилтнуудаас гаргасан өргөдөл, гомдол;
- Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны талаар гаргасан гомдол;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр шүүх, прокурор, өмгөөлөгч, мөрдөгчийн ажиллагаа, шийдвэрт гаргасан гомдол;
- Прокурорын байгууллагад гаргасан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл;
- Доод шатны прокурорын шийдвэр, үйл ажиллагааны талаар гаргасан гомдол;
- Төр, захиргааны болон эрх бүхий бусад байгууллагаас харьяаллын дагуу шилжүүлж ирүүлсэн өргөдөл, гомдол;
- Шүүхийн шийдвэр биелүүлэхтэй холбоотой асуудлаар гаргасан гаргасан гомдол гэх мэт.

¹⁰Прокурорын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 2017 он.

Мөн прокурорын байгууллага нь Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу иргэн таны гомдол, хүсэлтийг хүлээн авч дээрх хуульд заасан хугацааны дотор шийдвэрлэдэг болно.

Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ.¹¹

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “зөрчил шалган шийдвэрлэх” гэж зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ гэж заажээ.

Иргэн та хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргасан зөрчлийн талаар гомдол, мэдээллийг амаар, бичгээр болон харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан эрх бүхий байгууллагад гаргаж болно. Хэрвээ гомдол, мэдээллийг бичгээр гаргасан бол гомдол гаргагч эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, эсхүл шуудангийн хаяг, утасны дугаараа бичиж, гарын үсэг зурсан байна.

Эрх бүхий албан тушаалтан нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад энэ хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг илрүүлсэн, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн, зөрчил үйлдсэн хүн өөрийгөө илчилж ирсэн, байгууллага, албан тушаалтнаас харьяаллын дагуу зөрчлийн талаарх холбогдох баримтыг шилжүүлэн ирүүлсэн тохиолдолд прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

Дээрх заасан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг илрүүлсэн, эсхүл гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш эрх бүхий албан тушаалтан ажлын 3 өдрийн дотор шалгаж, гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх, хүлээн авахаас татгалзах, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх, зөрчлийн хэрэг нээх шийдвэрийн аль нэгийг гаргана.

¹¹Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2017 он.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу “Прокурор” зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах;
- Зөрчлийг өөрөө илрүүлсэн, мэдээлэл хүлээн авсан бол харьяаллын дагуу шилжүүлэх;
- Энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 2, 4, 5 дахь хэсэгт заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийн харьяаллыг тогтоох;
- Оролцогчийн гаргасан гомдол, бусад үндэслэлээр зөрчлийн хэргийг хянах;
- Хуульд заасны дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг сунгах;
- Эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтны шийдвэр, ажиллагааны талаарх гомдлыг хянан шийдвэрлэх;
- Прокурорын хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар эрх бүхий байгууллагад шаардлага хүргүүлэх;
- Энэ хуульд заасан прокурорын зөвшөөрлөөр явуулах ажиллагааны зөвшөөрөл олгох, хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй явуулсан ажиллагааг хуульд заасны дагуу явуулсан эсэхийг хянаж, хүчинтэйд тооцох эсэхийг шийдвэрлэх;
- Зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх;
- Зөрчил шалгах тодорхой ажиллагааг гүйцэтгүүлэхээр даалгавар өгөх;
- Эрх бүхий албан тушаалтны эрх хязгаарлах арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан саналыг шийдвэрлэх;
- Энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан эрх хязгаарлах арга хэмжээний хууль зүйн үндэслэлийг хянаж, үндэслэлгүй арга хэмжээ авсан бол цуцлах, саатуулагдсан хүнийг суллах;
- Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад эрх бүхий албан тушаалтан хууль зөрчсөн бол зөрчлийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар шалгуулахыг зогсоох талаар дээд шатны албан тушаалтанд шаардлага хүргүүлэх;
- Зөрчлийн хэрэг бүртгэлт, хяналтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичгийг гаргуулан авах, газар дээр нь танилцах, иргэн, албан тушаалтнаас тайлбар авах;
- Тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй бол эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, харьяаллын дагуу шилжүүлэх;
- Зөрчлийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох;
- Хуульд заасан бусад.

Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч зөрчлийн хэрэг бүртгэлтийн шатанд эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны талаар прокурорт бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж, шийдвэрийг гомдол гаргасан оролцогчид биечлэн танилцуулах, эсхүл харилцаа, холбооны хэрэгсэл ашиглан хүргүүлнэ.

Харин та прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн нэгжийн дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.

Зөрчлийн хэргийг гэмт хэргийн шинжтэй эсхүл илтэд зөрчил үйлдсэн үндэслэл тогтоогдвол эрх бүхий албан тушаалтны зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг прокурор хүчингүй болгож эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, эсхүл зөрчлийн хэрэг бүртгэлтэд буцаах бөгөөд шийдвэр гаргасан даруй эрх бүхий байгууллагад хэргийг шилжүүлнэ.

Прокурорын байгууллагад дээр дурдсанаар амаар болон бичгээр өргөдөл, гомдол гаргахаас гадна <http://prokuror.mn/?do=static&page=feedback> цахим хаягаар нэвтэрч өргөдөл, гомдлоо гаргах боломжтой байна.

2.2.7. Цагдаагийн байгууллага

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.¹²

Цагдаагийн байгууллагын тогтолцоо нь цагдаагийн төв байгууллага, түүний харьяа албад, аймаг, нийслэлийн цагдаагийн газар (хэлтэс), сум, дүүргийн цагдаагийн хэлтэс (тасаг, хэсэг)-ээс бүрдэнэ.

Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг нь:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх;
2. Нийгмийн хэв журмыг хамгаалах;
3. Нийтийн аюулгүй байдлыг хангах;

¹²Цагдаагийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг. 2017 он.

Цагдаагийн ерөнхий газарт өргөдөл, гомдлоо амаар болон бичгээр гаргаж болох ба цахилгаан шуудан, утас, факс, интернет, холбоо мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан, түүнчлэн бусад хүнээр дамжуулан гаргаж болно.

Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж гарын үсгээ зурж, холбоо барих утасныхаа дугаараа бичнэ. Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно.

Цагдаагийн төв болон орон нутгийн байгууллага нь дараах төрлийн өргөдөл гомдлыг хүлээн авна.



- а. Цагдаагийн алба хаагчидтай холбоотой /Цагдаагийн алба хаагчдаас архи уусан, бусдыг зодсон, хэрэг материал удаан шалгасан зэрэг хүний эрх, эрх чөлөө, цагдаагийн алба хаагчийн ёс зүй зөрчсөн/ гомдол мэдээлэл.
- б. Гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл
- в. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, алба тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал.

Цагдаагийн алба хаагчидтай холбоотой заасан гомдол, мэдээллийг 5 буюу 14 хоногт багтаан холбогдох албадаар шалгуулж шийдвэрлэн хариу өгөх бөгөөд бусад өргөдөл, гомдол, саналыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Шаардлагатай тохиолдолд уг хугацааг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Цагдаагийн алба хаагчидтай холбоотой заасан гомдол, мэдээллийг Нийслэлийн Цагдаагийн газрын хэв журмын албаны шуурхай удирдлагын төвд хандаж болно.

Иргэд ямар тохиолдолд цагдаагийн байгууллагад хандаж болох вэ?

- Гэмт хэрэг, нийгмийн хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;
- Гэмт хэрэг, нийгмийн хэв журам зөрчигдсэн үед түүнийг таслан зогсоох, учирч болзошгүй хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх;
- Гэмт хэрэг, нийгмийн хэв журам зөрчсөн тухай мэдээлэл өгөх;
- Иргэний эрх ашиг, сонирхол зөрчигдсэн бол;
- Бусад

Гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай иргэдийн гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулна.

Эрүүгийн гэмт хэргийн тухай өргөдөл, гомдол гаргах, шийдвэрлүүлэх нь ердийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхээс ялгаатай болно.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдэж байгаа тухай мэдээллийг иргэдээс авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй байх, нэмэгдүүлэхгүй байх шуурхай арга хэмжээ авна.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авсан прокурор 24 цагийн дотор харьяалах хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад шилжүүлж, хяналт тавьж ажиллана.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг 5 хоногт багтаан шалгаж, хариу өгөх ёстой бөгөөд нэмэлт тайлбар, баримт бичиг, бусад материал гаргуулж авах, хэргийн газрын үзлэг хийх шаардлагатай бол энэхүү хугацааг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга 14 хүртэл хоногоор сунгана.

Гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг шалгаад дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

- Эрүүгийн хэрэг үүсгэх;
- Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах;
- Гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх.

Цагдаагийн байгууллага зөрчил болон гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд гомдол гаргагч энэ талаар прокурорт хандаж, гомдол гаргах эрхтэй.

Гомдлыг хянаж байгаа албан тушаалтан бүрэн эрхийнхээ хүрээнд гомдол гаргагчийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг цаг алдалгүй авах үүрэгтэй.

Түүнчлэн гомдол, мэдээллийг шалгаж тодорхой шийдвэр гаргаж, энэ тухай гомдол гаргагч, мэдээлэгчид албан ёсоор хариу мэдэгдэх үүргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорт хуулиар оногдуулсан байдаг.


Иргэд аж ахуйн нэгж, байгууллагаас цагдаагийн байгууллагад амаар, биечлэн, утсаар өргөдөл, гомдол гаргахаас гадна <http://www.service.police.gov.mn/apply> цахим хаягаар гомдол гаргах боломжтой байна.


Ашигласан эх сурвалж:


1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Иргэдээс төрөөс байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль. 1995 он.
3. Захиргааны ерөнхий хууль. 2015 он.
4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2016 он.
5. Зөрчлийн тухай хууль / шинэчлэн найруулсан/. 2017 он.
6. Зөрчлийн шалган шийдвэрлэх тухай хууль. 2017 он.
7. Иргэний хууль. 2002 он.
8. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002 он.
9. Эрүүгийн хууль /шинэчлэн найруулсан/ 2015 он.
10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. /шинэчлэн найруулсан/ 2017 он.


ХОЛБОО БАРИХ:


Монгол Улс, Улаанбаатар хот
Скай Плаза Бизнес төв
Элчингийн гудамж 12
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо


 +976 11 328848

 +976 11 322415

 info@sam.mn

 www.sam.mn, www.asmhub.mn

 ASM Mongolia

 ASM_Mongolia

© Энэхүү гарын авлагыг худалдахыг хориглоно.